

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/163/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Ахлах аудитор: Д.Назгүл  
Утас: 99427301 Цахим хаяг: nazgul\_1972@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж .....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА А.КАМЕЛЯТ ТАНАА

2023.02.02 № 17  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Татварын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

### Аудитын гол асуудал

Аймгийн Татварын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бусад мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэх болон хийсэн

Татварын хэлтэс Дүгнэл-2.02-ТА

ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол аудитын тайландаа тусгах ёстой. Бусад асуудлын талаар аудитын тайланд тусгасан.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

			Төгрөгөөр
Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>14,359,331.63</u></b>	<b><u>20,476,450.63</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,729,311.00	5,296,270.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,729,311.00	5,296,270.00
3351	Байгууллагаас авах авлага	1,729,311.00	5,296,270.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	12,630,020.63	15,180,180.63
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	12,630,020.63	15,180,180.63
35410	Бичиг хэргийн материал	3,611,100.63	2,110,780.63
35420	Аж ахуйн материал	6,828,920.00	10,879,400.00
35470	Бусад хангамжийн материал	2,190,000.00	2,190,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>465,909,014.93</u></b>	<b><u>650,880,384.90</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	465,909,014.93	650,880,384.90
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	429,804,014.93	614,775,384.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	194,930,150.00	400,572,155.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,335,605.90)	(20,530,394.75)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	150,600,000.00	162,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(30,279,074.74)	(49,291,594.42)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	223,417,824.11	215,514,865.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	(96,156,339.30)	(96,653,935.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,838,402.18	22,535,749.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,368,094.56)	(20,026,518.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,410,452.00	2,877,402.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,253,698.86)	(2,822,344.46)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	36,105,000.00	36,105,000.00

39303	Бусад биет бус хөрөнгө	36,105,000.00	36,105,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>480,268,346.56</u></b>	<b><u>671,356,835.53</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>480,268,346.56</u></b>	<b><u>671,356,835.53</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	480,268,346.56	671,356,835.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	279,582,187.20	279,582,187.20
51101	Өмч: - төрийн	279,582,187.20	-
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	107,966,779.13	299,055,268.10
51210	Өмнөх үеийн үр дүн	95,868,536.82	107,966,779.13
51220	Тайлант үеийн үр дүн	12,098,242.31	191,088,488.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,719,380.23	92,719,380.23
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>480,268,346.56</u></b>	<b><u>671,356,835.53</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>954,896,860.08</b>	<b>1,170,489,315.06</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>83,945,460.08</b>	<b>249,594,515.06</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	83,945,460.08	249,594,515.06
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	83,945,460.08	249,594,515.06
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	83,945,460.08	249,594,515.06
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>870,951,400.00</b>	<b>920,894,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	868,451,400.00	897,894,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	868,451,400.00	897,894,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,500,000.00	23,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00	23,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>942,798,617.77</b>	<b>979,400,826.09</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>942,798,617.77</b>	<b>979,400,826.09</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	941,658,909.77	926,659,121.09
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	662,236,138.00	640,385,223.00
210101	Үндсэн цалин	370,976,087.00	404,824,920.00
210102	Нэмэгдэл	145,304,813.00	113,006,744.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,393,400.00	49,737,819.00
210104	Урамшуулал	86,561,838.00	72,815,740.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	89,493,500.00	86,226,200.00
210201	Тэтгэврийн даатгал	62,923,500.00	58,633,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,642,500.00	6,898,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,314,000.00	5,518,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,328,500.00	1,379,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,285,000.00	13,796,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,159,687.00	14,590,729.00
210301	Гэрэл, цахилгаан	1,679,510.00	1,937,030.00
210302	Түлш, халаалт	9,216,079.00	10,235,573.00
210303	Цэвэр, бохир ус	1,264,098.00	2,418,126.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,557,204.00	47,089,949.38
210401	Бичиг хэрэг	7,685,500.00	8,713,829.38
210402	Тээвэр, шатахуун	8,452,000.00	12,621,530.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,739,614.00	6,901,770.00
210404	Ном, хэвлэл	432,890.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,097,200.00	959,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,150,000.00	17,893,120.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,809,000.00	8,380,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	8,809,000.00	8,380,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,098,000.00	2,388,200.00
210702	Дотоод албан томилолт	1,098,000.00	2,388,200.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	54,091,050.00	69,903,004.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,764,846.00	68,963,179.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	170,776.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,204.00	120,412.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,750,000.00	-
210807	Газрын төлбөр	63,000.00	219,317.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	374,320.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	81,214,330.77	57,695,115.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,536,190.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,318,453.00	3,467,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,359,687.77	54,227,615.71
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,139,708.00	52,741,705.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,139,708.00	52,741,705.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,139,708.00	52,741,705.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>12,098,242.31</b>	<b>191,088,488.97</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>12,098,242.31</b>	<b>191,088,488.97</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>870951400.00</b>	<b>920894800.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>870951400.00</b>	<b>920894800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	868451400.00	897894800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	868451400.00	897894800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2500000.00	23000000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2500000.00	23000000.00

<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>870951400.00</b>	<b>920894800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>870951400.00</b>	<b>920894800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>869811692.00</b>	<b>862856825.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	663953798.00	638655912.00
210101	Үндсэн цалин	372693747.00	403095609.00
210102	Нэмэгдэл	145304813.00	113006744.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59393400.00	49737819.00
210104	Урамшуулал	86561838.00	72815740.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	89493500.00	86226200.00
210201	Тэтгэврийн даатгал	62923500.00	58633800.00
210202	Тэтгэмжийн даатгал	6642500.00	6898100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5314000.00	5518500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1328500.00	1379600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13285000.00	13796200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12159687.00	14590729.00
210301	Гэрэл, цахилгаан	1679510.00	1937030.00
210302	Түлш, халаалт	9216079.00	10235573.00
210303	Цэвэр, бохир ус	1264098.00	2418126.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	32677204.00	36946900.00
210401	Бичиг хэрэг	8805500.00	4155900.00
210402	Тээвэр, шатахуун	8452000.00	12621530.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4739614.00	6901770.00
210404	Ном, хэвлэл	432890.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1097200.00	959700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9150000.00	12308000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10770000.00	8652700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1000000.00	
210604	Урсгал засвар	9770000.00	8652700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1098000.00	2388200.00
210702	Дотоод албан томилолт	1098000.00	2388200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	54341050.00	71928684.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47764846.00	68963179.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	1000000.00	170776.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158204.00	120412.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55000.00	55000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5000000.00	2400000.00
210807	Газрын төлбөр	63000.00	219317.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5318453.00	3467500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5318453.00	3467500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1139708.00</b>	<b>58037975.00</b>

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1139708.00	58037975.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1139708.00	58037975.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	279,582,187.20	92,719,380.23	95,868,536.82	468,170,104.25
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>279,582,187.20</b>	<b>92,719,380.23</b>	<b>95,868,536.82</b>	468,170,104.25
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн			12,098,242.31	12,098,242.31
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>279,582,187.20</b>	<b>92,719,380.23</b>	<b>107,966,779.13</b>	480,268,346.56
<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>279,582,187.20</b>	<b>92,719,380.23</b>	<b>107,966,779.13</b>	480,268,346.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>279,582,187.20</b>	<b>92,719,380.23</b>	<b>107,966,779.13</b>	480,268,346.56
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			191,088,488.97	191,088,488.97
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>279,582,187.20</b>	<b>92,719,380.23</b>	<b>299,055,268.10</b>	671,356,835.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	897,894,800.00	845,153,095.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	897,894,800.00	845,153,095.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	897,894,800.00	845,153,095.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	689,809,300.00	638,655,912.00
210101	Үндсэн цалин	406,538,000.00	403,095,609.00
210102	Нэмэгдэл	131,144,600.00	113,006,744.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	62,436,000.00	49,737,819.00
210104	Урамшуулал	89,690,700.00	72,815,740.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	86,226,200.00	86,226,200.00
210201	Тэтгэврийн даатгал	58,633,800.00	58,633,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,898,100.00	6,898,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,518,500.00	5,518,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,379,600.00	1,379,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,796,200.00	13,796,200.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,778,300.00	14,590,729.00
210301	Гэрэл, цахилгаан	2,900,000.00	1,937,030.00
210302	Түлш, халаалт	10,278,300.00	10,235,573.00
210303	Цэвэр, бохир ус	2,600,000.00	2,418,126.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,585,400.00	24,243,170.00
210401	Бичиг хэрэг	4,155,900.00	4,155,900.00
210402	Тээвэр, шатахуун	5,634,000.00	3,917,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,606,800.00	6,901,770.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	880,700.00	959,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,308,000.00	8,308,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,052,700.00	6,052,700.00
210604	Урсгал засвар	6,052,700.00	6,052,700.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,408,000.00	2,388,200.00
210702	Дотоод албан томилолт	2,408,000.00	2,388,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	69,567,400.00	69,528,684.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,963,200.00	68,963,179.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,800.00	170,776.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,000.00	120,412.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	219,400.00	219,317.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,467,500.00	3,467,500.00

13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	897,894,800.00	845,153,095.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	897,894,800.00	845,153,095.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	897,894,800.00	845,153,095.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40.00	41.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	37.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	40.00	41.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	34.00	35.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>23000000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>23000000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	17703730.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12703730.00
210402	Тээвэр, шатахуун	8703730.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4000000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2600000.00
210604	Урсгал засвар	2600000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2400000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2400000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5296270.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5296270.00</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	5296270.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	23000000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	23000000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23000000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

##### ***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Баян-Өлгий аймгийн Татварын хэлтэс нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн орлогыг бүрдүүлэх чиг үүрэгтэй байгууллага.

Аймгийн Татварын хэлтэс нь 2022 онд “Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр “Монгол Улсын татварын болон бусад хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх, эрсдэлийн удирдлагад суурилсан татварын хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, мэдээллийн технологид тулгуурласан татварын алба болж, татвар төлөгч сайн дурын үндсэн дээр татвараа өөрөө ногдуулах, төлөх түвшинг нэмэгдүүлэх замаар татварын орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэх” зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

##### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Аймгийн Татварын хэлтэс нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсвийн байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Татварын ерөнхий газар нь аймгийн Татварын хэлтсийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Сүүлийн 3 жилд тус байгууллагын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

## **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Аймгийн Татварын хэлтэс нь Татварын Ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/156 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 191.1 сая төгрөгөөр буюу 39.7 хувиар өссөн байна.

#### *Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	0.00
Авлага	1,729.31	5,296.27	3,566.96
Бараа материал	12,630.02	15,180.18	2,550.16
Үндсэн хөрөнгө	465,909.01	650,880.38	184,971.37
<b>Нийт хөрөнгө</b>	<b>480,268.35</b>	<b>671,356.84</b>	<b>191,088.49</b>
Өр төлбөр	-	-	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	480,268.35	671,356.84	191,088.49
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>480,268.35</b>	<b>671,356.84</b>	<b>191,088.49</b>

Авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 3.6 сая төгрөгөөр өссөн нь оны эхний авлагыг барагдуулж, нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлсэн 5.3 сая төгрөгийг авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын данс 2.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн материалын орлоготой холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 184.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд үнэ төлбөргүй 239.2 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгөнд тайлант онд 54.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант онд 191.1 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 191.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 973.9 сая, зарлагыг 973.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас цалингийн зардлыг 26.2 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 20.0 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.5 сая, хангамж, бараа материалын зардлыг 17.1 сая, тавилга, эд хогшлын зардлыг 33.6 сая, томилолтын зардлыг 7.7 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 10.5 сая, нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 4.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 22.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 96.8 сая төгрөгөөр бууруулж 877.1 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт оны эцэст тодотгол хийж байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 1.3 сая, хангамж, бараа материалын зардлыг 9.3 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 5.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 4.8 сая, нийт 20.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 арга хэмжээ, 3 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 897.9 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 897.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 845.1 сая төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 52.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Татвар хураалт, орлого бүрдүүлэлт	897894.8	845153.1	-52741.7	94.1%
1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	833431.6	780689.91	-52741.7	93.7%
1.2	Харуул, хамгаалалтын зардал	21600	21600	0	100%
1.3	Холбооны суваг ашигласны хөлс	42863.2	42863.2	-0.021	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Татварын хэлтэс нь аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2022 онд 23.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, тээвэр шатахууны зардалд 8.7 сая, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлсийн зардалд 4.0 сая, урсгал засварт 2.6 сая, мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 2.4 сая, нийт 17.7 сая төгрөгийн зарцуулж, 5.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

#### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Аймгийн Татварын хэлтэс 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 19 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баян-Өлгий аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 942.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 18.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: Цалингийн зардлыг 51.1 сая, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлуудыг 1.2 сая, хангамж бараа материалын зардлыг 0.3 сая, томилолт зочны зардлыг 0.02 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.04 сая, нийт 52.7 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах алдаа, зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр тус байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй 150.0 мянган төгрөгийн ном, 45.0 мянган төгрөгийн сэтгүүл худалдан авсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах алдаа, зөрчил илэрч албан шаардлага өгсөн. Үүнд:

Батлагдсан орон тооны хязгаарыг хэтрүүлж, жижиг татвар төлөгчтэй харилцах тасагт 1 орон тоог илүү ажиллуулж төсвөөс 13.7 сая төгрөгийг үргүй зарцуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэх, 8 дугаар зүйлийн 8.2-т “энэ хуулийн 3.1.1.-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн эсэхийг хамруулан шалгалаа.

Татварын хэлтэс нь 2022 онд 1,238.0 сая төгрөгийн 119 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,152.5 сая төгрөгийн 117 мэдээллийг ил тод байршуулж, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 85.5 сая төгрөгийн 26 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75%, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 100% байна.

##### **Шийдвэрлэсэн нь:**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй шалгасан аудитаар төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 85.5 сая төгрөгийн 26 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй зөрчил гаргасан ба мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75 хувь байгаа тул албан шаардлага өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус байгууллагад завсрын аудит хийгдээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар батлагдсан орон тооны хязгаарыг зөрчиж 1 орон тоо илүү ажиллуулж байгаа зөрчлийг арилгасан эсэхийг хянаж үзэх шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23.0 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 23.0 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Нэмэлт санхүүжилтийн тайланг гаргаж ирүүлээгүй байсныг аудитын явцад нөхөж гаргуулан зөрчлийг арилгуулав.

Аудитаар нийт 0.9 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 0.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 5.1 Төлбөрийн акт

Амралтын цалин олгосон 6, 7, 8 дугаар саруудад программын алдаанаас болж зарим ажилтнуудын 663.3 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон, нэр бүхий ажилтнаас 300.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоосон.

### 5.2 Албан шаардлага

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруула агүй		Тоо	Дүн
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	23000.0	1	23000.0			1	23000.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>23000.0</b>	<b>1</b>	<b>23000.0</b>			<b>1</b>	<b>23000.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгуулл агад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Амралтын цалин олгосон 6, 7, 8 дугаар саруудад программын алдаанаас болж зарим ажилтнуудын 663.3 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон	1	663.3	1	663.3								
Нэр бүхий ажилтнаас 300.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй	1	300.0	1	300.0								
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>963.3</b>	<b>2</b>	<b>963.3</b>								

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 85.5 сая төгрөгийн 26 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна	1	85544.0			1	85544.0		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>85544.0</b>			<b>1</b>	<b>85544.0</b>		
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төсвийн хөрөнгөөр тус байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй 150.0 мянган төгрөгийн ном, 45.0 мянган төгрөгийн сэтгүүл худалдан авсан байна.	1	195.0	1	195.0				
Батлагдсан орон тооны хязгаарыг хэтрүүлж, жижиг татвар төлөгчтэй харилцах тасагт 1 орон тоог илүү ажиллуулсан.	1	13,767.5			1	13,767.5		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>13,962.5</b>	<b>1</b>	<b>195.0</b>	<b>1</b>	<b>13,767.5</b>		
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>99,506.5</b>	<b>1</b>	<b>195.0</b>	<b>2</b>	<b>99,311.5</b>		